

ХОРИН ХОЁРДУГААР БААЗ ХК

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 26/02

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Г “Хорин хоёр дугаар бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан 7 хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалтууд, компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.2.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих” журмыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026.04.29-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Энхтайвны өргөн чөлөө, өөрийн байрны 101 тоотод хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр баталсугай:
 1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах.
 2. Компанийн 2025 оны санхүүгийн тайланг танилцуулах.
 3. Компанийн санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлт.
 4. Ногдол ашиг хувиарлах тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах.
 5. Бусад.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04-р сарын 10-ний өдрөөр тасалбар болгосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 2026 оны 04 дүгээр сарын 07-ний өдөр дахин мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
5. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /З.ТУУЛ/-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурдсугай.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ын агуулгыг хавсралт 2-т зааснаар баталсугай.
8. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.

ХОРИН ХОЁРДУГААР БААЗ ХК

9. Тогтоолын хэрэгжилтийг хангах, ажлыг зохион байгуулах үүрэг бүхий хурал зохион байгуулах бөгөөд тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:
- Д.Солонго дарга
 - М.Нэргүй гишүүн
10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
11. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “22-р Бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /З.Туул/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ГҮНДЭГМАА